# СТРАТЕГИЙН

THE MONGOLIAN JOURNAL OF STRATEGIC STUDIES

№84 /2022/

# СУДАЛГАА

***Үндэсний аюулгүй байдлын зөвлөл байгуулагдсны 30 жилийн ойд зориулсан тусгай дугаар***

**СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ**

**Дарга**
Б.Даваадорж
ССХ-ийн Захирал, профессор

**Ерөнхий редактор**
доктор Ж.Мэндээ
ССХ-ийн Дэд захирал, Эрдэмтэн нарийн бичгийн дарга

**Гишүүд**
доктор, профессор З.Болдбаатар
доктор Э.Энхмаа
доктор Б.Отгонсүрэн
доктор Ц.Минжин
Н.Энхбаяр
Н.Соёлгэрэл

**Нарийн бичгийн дарга**
С.Буянхишиг

**Редакцын хаяг:**
Самбуугийн гудамж 11,
Засгийн газрын-11, 8 давхар
Утас: (976-51)264000
Факс: (976-11)324055

**Шуудангийн хаяг:**
Монгол Улс, Улаанбаатар
Төв шуудан- 870

**Захиалгын индекс:**
200952

**EDITOR’S BOARD**

**Editor in Chief**
B.Davaadorj
Director Prof, ISS

**Executive Editor**
J.Mendee Dr.
Deputy Director and Dean, ISS

**Members**
Z.Boldbaatar Dr. Prof
E.Enkhmaa Dr.
B.Otgonsuren Dr.
Ts.Minjin Dr.
N.Enkhbayar
N.Soyolgerel

**Secretary**
S.Buyankhishig

**Board Address:**
8th floor, Government Building-11,
Sambuu Str. 11
Tel: (976-51)264000
Fax: (976-11)324055

**Postal Address:**
Central Post Office 870
Ulaanbaatar

**Subscription index:**
200952

**Цахим хуудас: www.iss.gov.mn**

**Зохиогчийн эрх:** @ Стратеги судалгааны хүрээлэн, 2022
Сэтгүүлд нийтэлсэн материалын агуулга, мэдээллийн үнэн зөвийг зохиогчид хариуцна.

**Дугаар эрхэлсэн:** ССХ-ийн Хүрээлэн буй орчны аюулгүй байдлын судалгааны төв

# ӨМНӨХ ҮГ

Эрхэм уншигч Та бүхнийхээ оюуны мэлмийд толилуулахаар ҮАБЗ байгуулагдсаны 30 жилийн ойд зориулсан "Стратегийн судалгаа" сэтгүүлийн 84 дүгээр тусгай дугаарыг өргөн барьж байна.

Монгол Улсад төр, нийгмийн байгууллын шинэчлэл эхэлсэн тэр цаг үед үндэсний аюулгүй байдлаа бие даан хадгалан, хамгаалах асуудал монгол түмний өмнө нэгэн цоо шинэ зорилго болон тавигдаж, энэ асуудлыг цогцоор судлах, төрийн бодлогын түвшинд авч үзэх зайлшгүй шаардлага гарсан билээ. Энэ нь тэр үед дэлхийн геополитикийн ертөнцөд гарсан эрс өөрчлөлтөд нийцүүлэн Монгол Улсын төрийн бодлогыг энхийг эрхэмлэсэн, олон тулгуурт болгон өөрчлөн боловсруулж, хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага гарсантай ч бас уялдаатай байсан юм.

Ингээд 1992 оны тавдугаар сарын 29-ний өдөр шинэ Үндсэн хуулийн үзэл санаа, холбогдох заалтуудад үндэслэн Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн тухай хуулийг УИХ-аар хэлэлцэн баталснаар энэ Зөвлөлийг эмхлэн байгуулах эрх зүйн үндэс бүрдсэн юм. Үүнээс хойш даруй 30 жил өнгөрлөө.

Улс орны түүхэн хөгжлийн энэхүү нэгэн зурвас хугацаанд Монгол үндэстний оршин тогтнохуй, үндэсний язгуур ашиг сонирхлыг хадгалан хамгаалахад чиглэсэн олон чухал асуудлыг шийдвэрлэж чадсан бөгөөд үүнд шинээр байгуулагдсан ҮАБЗ-ийн үе үеийн Тэргүүн, гишүүд, зөвлөх, илтгэгч, шинжээч, Зөвлөлийн Ажлын алба, Стратеги судалгааны хүрээлэнгийн эрдэмтэн, судлаачид амжилттай оролцож, дорвитой хувь нэмрээ оруулсан юм.

Орчин үеийн олон улсын харилцаанд шинэ маягийн хүйтэн дайны уур амьсгал нэгэнт



**ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Ж.ЭНХБАЯР**

бий болж эхэлсэн өнөөгийн энэ ээдрээтэй цаг үе, нөхцөл байдалд үндэсний аюулгүй байдлаа хадгалан хамгаалж үлдэх эрхэм үүрэг бидний өмнө дахин шинээр тавигдаж байна. Энэхүү өргөн цар хүрээтэй шинэ аюул, заналын түвшнийг үнэн зөвөөр тодорхойлох, үнэлэх, учирч болзошгүй эрсдэл, сорилтоос урьдчилан сэргийлэхэд чиглэсэн төрийн бодлогыг оновчтой тодорхойлоход бодитой хувь нэмрээ оруулах нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн өмнө тавигдаж буй нэн хариуцлагатай үүрэг, даалгавар болж байна.

Үүний дотор аюулгүй байдлын гадаад орчин, дотоод нөхцөл байдал хурдацтай өөрчлөгдөж буйтай уялдаатайгаар ҮАБЗ-ийн судалгаа, мэдээлэл, дүн шинжилгээний үндсэн байгууллага болох Стратеги судалгааны хүрээлэнгийн үүрэг роль улам бүр өсөн нэмэгдэж байгаа өнөө цаг үед энэхүү тусгай дугаарыг бэлтгэн гаргаж байгаа нь чухал юм.

Тус хүрээлэн үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн Монгол Улсад аюулгүй байдал, стратегийн судалгааг хөгжүүлэх, эрдэмтэн, судлаачдын бүтээлийг хэвлэн нийтлэж, олны хүртээл болгох эрхэм үйл хэргийг эрхлэн гүйцэтгэж ирсэн сайхан уламжлалаа амжилттай үргэлжлүүлж байгаад баяртай байна.

Энэ удаагийн тусгай дугаарт өнөө үеийн эрдэмтэн, судлаачдын бичсэн өгүүлэл, нийтлэлийн зэрэгцээ, ҮАБЗ-ийн Ажлын албаны болон Стратеги судалгааны хүрээлэнгийн ахмадуудын үндэсний аюулгүй байдлын онол, эрх зүй, практиктай холбогдол бүхий, асуудал дэвшүүлсэн материалууд нийтлэгдэн, анх удаагаа олны хүртээл болж байгаа нь туйлын сайн хэрэг.

Манай ахмад судлаачдын тухайн үедээ бичиж үлдээсэн өгүүлэл, нийтлэл нь улс орныхоо үндэсний аюулгүй байдал хэмээх амин чухал асуудалд сэтгэл зүрхээ зориулсан, энэ асуудлыг үнэн сэтгэлээсээ сонирхдог хүн бүрийн унших, бодох, эргэцүүлэх эрмэлзлийг өдөөсөн, шинэ санаа бодолд уриалан дуудсан үнэ цэнэтэй эх сурвалж болно гэдэгт итгэлтэй байна.

Монгол төрийн тусгаар тогтнол, аюулгүй байдал мөнхөд батжин бэхжиж, эрдэм оюун суу билэг ундрах болтугай!

# АГУУЛГА CONTENT


**АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДЛААР АНХ УДАА ОЛНЫ ХҮРТЭЭЛ БОЛЖ БУЙ ӨГҮҮЛЭЛ, НИЙТЛЭЛ**

**ARTICLES ON NATIONAL SECURITY FIRST RELEASED IN THIS ISSUE**

**С.Баяр** / **S.Bayar**

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын Үзэл баримтлалын талаарх санал, дүгнэлт, зөвлөмж — 6 — Opinions, findings and recommendations on the Concept of National Security of Mongolia

**доктор Р.Болд** / **R.Bold (Ph.D)**

Орос, Хятадын стратегийн түншлэлийн дунд Монгол төвийг сахих нь — 39 — Mongolia's neutrality in the strategic partnership between Russia and China

**дэслэгч генерал Ч.Пүрэвдорж** / **Ch.Purevdorj**

НҮБ-ын Энхийг сахиулах үйл ажиллагааны шинэ үе — 47 — A new era in UN peacekeeping operations

**Ч.Пүрэвдорж, Р.Болд** / **Ch.Purevdorj, R.Bold**

Гадаадын орнууд дахь аюулгүй байдлын бодлого эрхэлсэн төр, Засгийн газрын байгууллагууд — 55 — State and government agencies in charge of security policy in foreign countries

**доктор, профессор Д.Мягмар** / **D.Myagmar (Sc.D)**

Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдал: тулгамдсан зарим асуудал, шийдвэрлэх арга зам — 73 — The Existential security of Mongolia: Challenges and solutions

**АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДЛААР АХМАД ШИНЖЭЭЧДИЙН БАЙР СУУРЬ**

**POSITIONS OF SENIOR EXPERTS ON SECURITY ISSUES**

**Л.Болдбаатар** / **L.Boldbaatar**

Өнөөгийн Монгол Улсын аюулгүй байдлын гадаад орчны төлөв байдал — 82 — Current state of Mongolia's external security environment

**Г.Пушкин** / **G.Pushkin**

Монгол Улсын хил, хязгаар нутгийн хамгаалалтын түүхэн сургамж — 90 — Historical lessons of Mongolia's border and adjacent area protection

**Б.Баярсайхан** — **B.Bayarsaikhan**

Хилийн аюулгүй байдлыг хангахад тулгамдаж буй асуудал ба хил дамнасан чөлөөт бүс 101 Pressing issues for Border Security and cross-border free trade zone

**Д.Нэргүй** — **D.Nergui**

Хязгаар нутгийн хүн амын суурьшил Үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх нь 110 Impact of border area population settlement on national security

**доктор Ч.Оюунчимэг**
**доктор Ц.Даваадорж** — **Ch.Oyunchimeg (Ph.D)**
**Ts.Davaadorj (Ph.D)**

Синтетик биологи ба үндэсний аюулгүй байдал 122 Synthetic biology and national security

**доктор, дэд профессор Б.Ширнэн** — **B.Shirnen (Ph.D, Associate Prof)**

“Үндэсний адилсал” монголчуудын хөгжлийн түлхүүр 137 National identity-As a key the development of Mongolian people

**Д. Энхбат** — **D.Enkhbat**

Мэдээллийн технологи сэтгэхүйн нөлөөлөл 149 Influence of information technology on human intellect

**“ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУЛГАМДСАН АСУУДАЛ” ШИЛДЭГ НИЙТЛЭЛ** — **WINNING ESSAY OF THE STUDENT ESSAY COMPETITION**

**Х.Гүнчин-Иш** — **Kh.Gunchin-Ish**

Гурван хөршийн хурцадмал харилцаа ба шинэ хүйтэн дайны эрсдэл 159 Tensions between the three neighbors and the risks of a new Cold War

**МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ** 175 **NEWS**